



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

### Аудитын код: АРА-2026/179/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a>	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860
Архангай аймаг 2026 он	Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatard@audit.gov.mn">Nerguibaatard@audit.gov.mn</a> Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: <a href="mailto:Tsogerdeneg@audit.gov.mn">Tsogerdeneg@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....</b>	<b>10</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.3 Тайлант хугацааны ерөнхий чиглэлийн талаар .....	13
3.5.4 Нэмэлт төсөв .....	13
3.5.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН.....</b>	<b>14</b>
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>15</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....</b>	<b>15</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>15</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....</b>	<b>16</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>17</b>
<b>5.1 Албан шаардлага .....</b>	<b>17</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>17</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 104

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖИМТ  
ДРАМЫН ТЕАТРЫН ДАРГА  
Ж.НЯМСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь тайлант онд Соёл урлагийн хөтөлбөрийн 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр улс, орон нутгийн төсвөөс 2,070,969.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,692,574.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 123,484.9 мянган төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлж, нийт 1,828,820.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, үр дүнг тайлагнаж аймгийн Засаг даргаас 91.8 хувьтай үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>776,798,739.50</u></b>	<b><u>846,095,637.50</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	776,798,739.50	846,095,637.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	776,798,739.50	846,095,637.50
35410	Бичиг хэргийн материал	292,500.00	259,500.00
35420	Аж ахуйн материал	740,491,923.50	824,569,537.50
35430	Сэлбэг хэрэгсэл	4,247,000.00	2,447,000.00
35440	Түлш, шатах тослох материал	29,147,316.00	5,979,600.00
35450	Барилгын засварын материал	2,620,000.00	12,740,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	100,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,630,469,923.15</u></b>	<b><u>3,605,620,476.09</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,630,469,923.15	3,605,620,476.09
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,422,565,660.65	3,398,859,663.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	733,835,389.86	733,835,389.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(121,144,084.74)	(162,637,723.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,152,000.00	145,933,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,752,000.18)	(62,667,083.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,833,699,395.00	2,096,348,396.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(219,932,807.00)	(423,452,328.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	273,165,865.90	1,263,940,802.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(111,846,742.32)	(217,705,100.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,179,500.00	30,179,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,790,855.87)	(4,915,189.15)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	207,904,262.50	206,760,812.50
39301	Программ хангамж	8,060,700.00	8,060,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,676,437.50)	(2,819,887.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	201,520,000.00	201,520,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,407,268,662.65</u></b>	<b><u>4,451,716,113.59</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,407,268,662.65</u></b>	<b><u>4,451,716,113.59</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,407,268,662.65	4,451,716,113.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	543,983,879.45	543,983,879.45
51101	Өмч: - төрийн	543,983,879.45	543,983,879.45
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,664,931,906.55	3,709,379,357.49
51210	Өмнөх үеийн үр дүн	2,664,931,906.55	2,664,931,906.55
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,044,447,450.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	198,352,876.65	198,352,876.65
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,407,268,662.65</u></b>	<b><u>4,451,716,113.59</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,887,840,484.52</b>	<b>3,570,939,517.00</b>

**Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,958,828,968.00</b>	<b>1,509,970,017.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,958,828,968.00	1,509,970,017.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	132,727,650.00	136,245,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,727,650.00	136,245,950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,769,601,208.00	1,353,233,563.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	56,500,110.00	20,490,504.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,929,011,516.52</b>	<b>2,060,969,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,531,420,716.52	1,645,293,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,531,420,716.52	1,645,293,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	397,590,800.00	415,675,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,590,800.00	415,675,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,226,809,963.76</b>	<b>2,526,492,066.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,226,809,963.76</b>	<b>2,526,492,066.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,738,133,454.61	2,078,024,686.52
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,183,057,754.39	1,350,118,696.35
210101	Үндсэн цалин	753,881,831.30	779,747,700.00
210102	Нэмэгдэл	282,206,498.53	428,718,158.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,416,000.00	48,242,848.00
210104	Урамшуулал	103,553,424.56	93,409,990.03
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	144,489,719.20	161,783,522.99
210201	Тэтгэврийн даатгал	99,450,589.33	112,552,066.07
210202	Тэтгэмжийн даатгал	11,696,538.04	13,030,246.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,164,000.00	6,705,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,705,819.77	6,425,194.86
210205	Эрүүл мэндийн даатгал	21,472,772.06	23,070,815.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,317,601.77	74,808,061.12
210301	Гэрэл, цахилгаан	12,819,494.00	15,864,048.00
210302	Түлш, халаалт	44,863,904.00	56,070,316.00
210303	Цэвэр, бохир ус	1,634,203.77	2,873,697.12
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,011,346.21	29,961,560.00
210401	Бичиг хэрэг	2,459,900.00	1,883,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,280,000.00	13,635,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	897,685.21	1,062,235.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,336,910.00	2,999,810.00
210408	Бараа материал акталсны зардал	7,466,851.00	10,381,315.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	960,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	960,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,425,040.00	13,911,300.00
210604	Урсгал засвар	13,425,040.00	13,911,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	28,114,400.00	11,753,200.00
210702	Дотоод албан томилолт	28,114,400.00	11,753,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	70,126,540.00	17,403,080.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,646,540.00	16,953,080.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,030,000.00	-
210807	Газрын төлбөр	450,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	212,631,053.04	418,285,266.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,054,902.00	9,967,556.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	210,576,151.04	408,317,710.06
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	488,676,509.15	448,467,379.54

**Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	86,540,799.00	80,072,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,255,900.00	11,338,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,884,899.00	30,492,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	38,242,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	321,544,382.23	350,878,854.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,544,382.23	350,878,854.88
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	80,591,327.92	17,516,424.66
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,591,327.92	17,516,424.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,661,030,520.76</b>	<b>1,044,447,450.94</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,661,030,520.76</b>	<b>1,044,447,450.94</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,061,739,166.52</b>	<b>2,197,215,450.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>132,727,650.00</b>	<b>136,245,950.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	132,727,650.00	136,245,950.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	132,727,650.00	136,245,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,727,650.00	136,245,950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,929,011,516.52</b>	<b>2,060,969,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,531,420,716.52	1,645,293,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,531,420,716.52	1,645,293,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	397,590,800.00	415,675,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,590,800.00	415,675,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,084,287,497.22</b>	<b>2,166,980,750.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,084,287,497.22</b>	<b>2,166,980,750.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,595,610,988.07</b>	<b>1,718,513,370.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,184,677,093.89	1,350,118,696.35
210101	Үндсэн цалин	755,501,170.80	779,747,700.00
210102	Нэмэгдэл	282,206,498.53	428,718,158.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,416,000.00	48,242,848.00
210104	Урамшуулал	103,553,424.56	93,409,990.03
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	144,489,719.20	161,783,522.99
210201	Тэтгэврийн даатгал	99,450,589.33	112,552,066.07
210202	Тэтгэмжийн даатгал	11,696,538.04	13,030,246.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,164,000.00	6,705,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,705,819.77	6,425,194.86
210205	Эрүүл мэндийн даатгал	21,472,772.06	23,070,815.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	79,438,377.77	52,560,345.12
210301	Гэрэл, цахилгаан	12,819,494.00	15,864,048.00
210302	Түлш, халаалт	64,984,680.00	33,822,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,634,203.77	2,873,697.12
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,833,055.21	18,627,245.00
210401	Бичиг хэрэг	2,691,800.00	1,850,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,200,000.00	12,715,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	897,685.21	1,062,235.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,473,570.00	2,999,810.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,127,040.00	24,997,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,213,000.00	-

**Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	7,914,040.00	24,997,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>28,114,400.00</b>	<b>11,753,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	28,114,400.00	11,753,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>127,332,400.00</b>	<b>74,832,761.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,852,400.00	74,382,761.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,030,000.00	-
210807	Газрын төлбөр	450,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,598,902.00</b>	<b>23,840,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,598,902.00	23,840,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>488,676,509.15</b>	<b>448,467,379.54</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>86,540,799.00</b>	<b>80,072,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,255,900.00	11,338,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,884,899.00	30,492,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	38,242,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>321,544,382.23</b>	<b>350,878,854.88</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,544,382.23	350,878,854.88
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>80,591,327.92</b>	<b>17,516,424.66</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,591,327.92	17,516,424.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(22,548,330.70)</b>	<b>30,234,700.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>29,581,800.00</b>	<b>30,234,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,581,800.00</b>	<b>30,234,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>29,581,800.00</b>	<b>30,234,700.00</b>
222001	Тоног төхөөрөмж	29,581,800.00	30,234,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(29,581,800.00)</b>	<b>(30,234,700.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(52,130,130.70)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	543,983,879.45	198,352,876.65	2,664,931,906.55	3,407,268,662.65
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	543,983,879.45	198,352,876.65	2,664,931,906.55	3,407,268,662.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-

**Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>543,983,879.45</b>	<b>198,352,876.65</b>	<b>2,664,931,906.55</b>	3,407,268,662.65
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>543,983,879.45</b>	<b>198,352,876.65</b>	<b>2,664,931,906.55</b>	3,407,268,662.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>543,983,879.45</b>	<b>198,352,876.65</b>	<b>2,664,931,906.55</b>	3,407,268,662.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,044,447,450.94	1,044,447,450.94
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>543,983,879.45</b>	<b>198,352,876.65</b>	<b>3,709,379,357.49</b>	4,451,716,113.59

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,188,930,400.0</b>	<b>1,828,820,170.5</b>	360,110,229.5	83.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,188,930,400.0	1,828,820,170.5	360,110,229.5	83.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,108,375,700.0	1,748,748,070.5	359,627,629.5	82.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,351,113,200.0	1,350,118,696.4	994,503.7	99.9
210101	Үндсэн цалин	779,747,700.0	779,747,700.0	-	100.0
210102	Нэмэгдэл	429,340,500.0	428,718,158.3	622,341.7	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,510,000.0	48,242,848.0	267,152.0	99.4
210104	Урамшуулал	93,515,000.0	93,409,990.0	105,010.0	99.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	168,889,300.0	161,783,523.0	7,105,777.0	95.8
210201	Тэтгэврийн даатгал	115,247,800.0	112,552,066.1	2,695,733.9	97.7
210202	Тэтгэмжийн даатгал	13,410,400.0	13,030,246.9	380,153.1	97.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,705,200.0	6,705,200.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	6,705,200.0	6,425,194.9	280,005.1	95.8
210205	Эрүүл мэндийн даатгал	26,820,700.0	23,070,815.2	3,749,884.8	86.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	390,675,800.0	52,560,345.1	338,115,454.9	13.5
210301	Гэрэл, цахилгаан	67,977,300.0	15,864,048.0	52,113,252.0	23.3
210302	Түлш, халаалт	276,882,300.0	33,822,600.0	243,059,700.0	12.2
210303	Цэвэр, бохир ус	45,816,200.0	2,873,697.1	42,942,502.9	6.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,633,200.0	18,627,245.0	5,955.0	100.0
210401	Бичиг хэрэг	1,850,000.0	1,850,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	12,715,200.0	12,715,200.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,068,000.0	1,062,235.0	5,765.0	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.0	2,999,810.0	190.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	55,234,700.0	55,232,300.0	2,400.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,234,700.0	30,234,700.0	-	100.0
210604	Урсгал засвар	25,000,000.0	24,997,600.0	2,400.0	100.0

**Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	12,000,000.0	11,753,200.0	246,800.0	97.9
210702	Дотоод албан томилолт	12,000,000.0	11,753,200.0	246,800.0	97.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>				
		87,153,500.0	74,832,761.0	12,320,739.0	85.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,703,500.0	74,382,761.0	12,320,739.0	85.8
210807	Газрын төлбөр	450,000.0	450,000.0	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>				
		24,676,000.0	23,840,000.0	836,000.0	96.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,676,000.0	23,840,000.0	836,000.0	96.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>				
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>				
		80,554,700.0	80,072,100.0	482,600.0	99.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,338,000.0	11,338,000.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,492,500.0	30,492,100.0	400.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,724,200.0	38,242,000.0	482,200.0	98.8
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,188,930,400.0</b>	<b>1,828,820,170.5</b>	360,110,229.5	83.5
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
		1,655,293,700.0	1,627,777,275.3	27,516,424.7	98.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,655,293,700.0	1,627,777,275.3	27,516,424.7	98.3
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
		415,675,800.0	64,796,945.1	350,878,854.9	15.6
132001	Орон нутгийн төсвөөс	415,675,800.0	64,796,945.1	350,878,854.9	15.6
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>				
		117,960,900.0	136,245,950.0	(18,285,050.0)	115.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	117,960,900.0	136,245,950.0	(18,285,050.0)	115.5
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
			-	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
			-	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>				
		60.0	50.0	10.0	83.3
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	49.0	43.0	6.0	87.8
620003	Үйлчлэх ажилтан	10.0	6.0	4.0	60.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>				
		11.0	10.0	1.0	90.9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.0	10.0	1.0	90.9

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус байгууллага нь Соёлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд Хөгжимт драмын театр нь “Ажиллах таатай орчин бүрдүүлж үйлчилгээний нэр төрөл чанар, хүртээмжийг сайжруулах, байгууллагын хүний нөөцийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, ардын болон сонгодог урлагийг орчин үеийн урлагтай хослуулан хөгжүүлэх, байгууллагын материаллаг хангамжийг дээшлүүлэх, гадаад дотоод харилцааг хөгжүүлэх, уран бүтээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх” гэсэн зорилт тавин ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Хөгжимт драмын театр нь аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын харьяа улсын төсвийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль - 2025.06.25, 2025.07.09

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд тус байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн СХДАГ-аас дотоод хяналт шалгалтыг зохион байгуулжээ. Хяналт шалгалтаар байгууллагын стратеги төлөвлөгөөг батлуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулжээ. Иймд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Соёлын сайдын 2022 оны 01 сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Хөгжимт драмын театр нь 2019 оноос СИ ТИ ЭС санхүүгийн системийг ашиглаж байгаа ба 2025 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн боловч маягт нь өөрчлөгдөөгүй хуучнаар буюу өмнөх хувилбараар байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,044,447.5 мянган төгрөгөөр буюу 30.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Бараа материал	776,798.7	846,095.6	69,296.9	8.9
Үндсэн хөрөнгө	2,630,469.9	3,605,620.5	975,150.6	37.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,407,268.7</b>	<b>4,451,716.1</b>	1,044,447.5	30.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,407,268.7	4,451,716.1	1,044,447.5	30.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,407,268.7</b>	<b>4,451,716.1</b>	<b>1,044,447.5</b>	30.7

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 8.9 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 776,798.7 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 136,742.4 мянган төгрөг, Соёлын яамнаас шинэ театрын барилга ашиглалтад орохтой холбоотой гал тогооны хэрэгсэл болон зөөлөн эдлэл 20,490.5 мянган төгрөг, нийт 157,232.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 77,554.6 мянган төгрөг, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийн дагуу аж ахуйн материалын данснаас хуучин хувцас, тайз, жижиг хэрэгслийг акталж данснаас хассан 10,381.3 мянган төгрөг, нийт 87,935.9 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 846,095.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 37.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 2,630,469.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд ОНӨГ-ын 2025.10.31-ны 403, 2025.11.10-ны өдрийн 527 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээс нэн шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авсан 30,234.7 мянга, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжин хэрэгжсэн 2,868,681.7 мянган төсөвт өртөгтэй ХДТ-ын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлэх гэрээний дагуу шинэ театрын тоног төхөөрөмж 1,353,233.5 мянга нийт 1,383,468.3 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Тайлант хугацаанд аймгийн ОНӨГ-ын 2025.11.10-ны өдрийн 516 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хассан 42,263.3 мянган төгрөг, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 408,317.7 мянган төгрөгөөр буурч, 975,150.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй биет бус хөрөнгө нь 201,520.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 150,000.0 мянган төгрөгийн үнэлгээтэй 15000м<sup>2</sup> талбайтай шинэ театрын газар, 51,520.0 мянган төгрөгийн үнэлгээтэй 5152м<sup>2</sup> талбайтай хуучин театрын барилгын газар тус тус бүртгэсэнтэй холбоотой байна.

Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой: Тус байгууллагын программ хангамжид 2018 оноос ашиглаж ирсэн 1,200.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй Си ти Эс санхүүгийн систем, 2024 оноос ашиглаж эхэлсэн 6,870.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй лед дэлгэц тоглуулагч программ бүртгэлтэй байгаа бөгөөд тайлант онд 450.0 мянган төгрөгөөр лиценз сунгалт хийлгүүлжээ.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнг 1,044,447.5 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,955,741.6 мянга, орон нутгийн төсвөөс 1,040,453.6 мянга нийт 4,996,195.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, аймгийн ХДТ-ын 2024.06.25-ны өдрийн 78 дугаар албан бичгээр аймгийн Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын газарт 2024.06.27-ны өдрийн 81 дугаар албан бичгээр аймгийн ЗДТГ-ын СТСХ-т тус тус хүргүүлжээ.

Төсвийн төслийн саналаас 2,221,139.6 мянган төгрөгөөр бууруулан зардлыг анх улсын төсвөөс 1,734,602.0 мянга, харин 142,701.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тогтмол зардлыг анх орон нутгийн төсвөөс 1,183,154.7 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд батлагдсан төсөвт 1 удаа тодотгол хийгдсэн, төсвийн сар, улирлын хуваарьт 2 удаа өөрчлөлт орсон байна. 2025 оны 07 дугаар сарын тодотголоор цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 39,656.9 мянга, ажил олгогчоос НДШ-д төлөх зардлыг

4,957.2 мянга, хангамж бараа материалын зардлыг 3,500.0 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 3,397.0 мянга нийт 162,348.6 мянган төгрөгөөр бууруулж 1,773,254.6 мянган төгрөгийг тодотголоор баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 2,188,930.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 1,655,293.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 415,675.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 117,960.9 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,828,820.2 мянган төгрөг буюу 83.5 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдсэн 17,516.4 мянган төгрөгийг улсын төсөвт, 350,878.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ. Цалин, шимтгэлээс 8,100.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 338,115.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 12,320.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	<b>71702-Соёл урлаг</b>	<b>2,188,930.40</b>	<b>1,828,820.16</b>	<b>360,110.24</b>	<b>83.55</b>
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,519,214.50	1,511,114.03	8,100.47	99.47
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	30,492.50	30,492.10	0.40	100.00
1.3	80112-Нийтлэг үйлчилгээ	415,675.80	77,557.95	338,117.86	18.66
1.4	81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	75,586.70	74,750.70	836.00	98.89
1.5	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	117,960.90	114,905.39	3,055.51	97.41
1.6	80214-Уран бүтээл хийлгэх	30,000.00	20,000.00	10,000.00	66.67

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Тайлант хугацааны ерөнхий чиглэлийн талаар

- ✓ Тус байгууллага нь дарга, захиргаа аж ахуйн анги-21, бүжиг анги-13, драм анги-6, найрал дууны анги-10, хөгжим анги-10 нийт 60 орон тоотой бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн хүрээнд цалингийн сан нь гүйцэтгэлээр буурч 50 орон тоогоор батлагдсан хэдий ч Хөгжимт драмын театрын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдаагүй байна.
- ✓ Тайлант онд төрд учирсан хохиролтой холбоотой асуудал байхгүй байна.
- ✓ Үндсэн үйл ажиллагааны зардлаас өдөрт 1 албан хаагчид 4,000 төгрөгөөр тоцон тайлант онд нийт 48,150.0 мянган төгрөгийг зарцуулсанд ерөнхий чиглэлийн судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- ✓ Программ хангамжийн бүртгэлд 8,060.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба санхүүгийн болон лед дэлгэц тоглуулагч 2 программыг ерөнхий чиглэлийн судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- ✓ Тайлант онд аймгийн АВ телевизтэй хамтран ажиллахаар 2,500.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 1,250.0 мянган төгрөгийг шилжүүлсэнд ерөнхий чиглэлийн судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- ✓ Тайлант онд гадаад томилолт болон сургалт, семинарын зардал гараагүй байна.

Ерөнхий чиглэлийн судалгааг ажлын баримтад хавсаргав.

### 3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд гүйцэтгэлд суурилсан үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын хувьд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

### **3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, үр дүнг тайлагнаж аймгийн Засаг даргаас 91.8 хувьтай үнэлсэн байна.

### **3.5.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Архангай аймгийн Хөгжимт драмын театр нь тайлан онд Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнээс давсан 1 бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна. Үүнд:

- ✓ Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 26,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нүүрс худалдан авах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж Булган хангайн хүлэг ХХК шалгарч 19,800.0 мянган төгрөгийн нүүрс нийлүүлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хөгжимт драмын театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Аймгийн Хөгжимт драмын театр нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны тодотгон баталсан төсөв 2,150,277.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 32,254.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 22,577.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь цалин, нэмэгдэл урамшуулал, НДШ, тогтмол болон урсгал зардлаас хэмнэлт бий болгож улсын төсөвт 17,516.4 мянга, орон нутгийн төсөвт 350,878.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Хөгжимт драмын театр нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 168 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг [fas.audit.mn](http://fas.audit.mn) системд 2025 оны 10 сарын 02-оос 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар залруулагдаагүй нийт 14,148.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон бөгөөд биелэлтийг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	14,148.6	1	14,148.6	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>14,148.6</b>	<b>1</b>	<b>14,148.6</b>	<b>100</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлөвлөсөн хэмжээнээс илүү 54.67 тн нүүрсийг нөөцөлсөн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож биелэлтийг хангасан ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлд “СИ ТИ ЭС” санхүүгийн программ ашигладаг бөгөөд тус программыг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын хавсралтаар баталсан санхүүгийн тайлангийн маягтуудтай нийцэж байгаа эсэхийг авч үзэх нь зүйтэй байна.
2. Хөгжимт драмын театрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж цалин, нэмэгдлийг хууль, журмын тооцож олгосон эсэхийг давтан тооцоолох нь зүйтэй.
3. Үндсэн хөрөнгийн хөдлөлийг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэхийг тулган шалгах нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар тооцсон материаллаг байдлын дүнтэй харьцуулахад материаллаг байдлын түвшнээс доогуур байгаа тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт хүргүүлэв.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 92,011,236.6 төгрөгийн 4 нэр төрлийн 320 ширхэг тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бусад хөрөнгийг актлах, данснаас хасах, үнийг шинэчлэн тогтоох зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “...эд хөрөнгийн үр дүнг шийдвэрлэх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ...”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох ...” гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгаж холбогдох арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
анхны өртгөө бүрэн нөхсөн 92,011,236.6 төгрөгийн 4 нэр төрлийн 320 ширхэг тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж бүртгэлтэй	1				1							
Дүн	1				1							